



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2021 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/426

Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 218 дугаар тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм”, 2021 оны “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм” 212 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алтай сумд байрлах Бургастайн хилийн боомтод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудыг байнгын цахилгаан эрчим хүчээр хангах зорилгоор хийгдсэн ЦДАШ, дэд станцын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Г.Чинбат	-(аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүдэд:	Ж.Мөнхцэцэг	-(аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	М.Мандаххүү	-(аймгийн Засаг даргын Тамгын газрын газрын Архивын тасгийн дарга)
	Ц.Амарсанаа	-(Онцгой байдлын газрын гал түймрийн хяналтын улсын байцаагч, хошууч)
	Д.Отгонжаргал	-(Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
	Б.Лхагва-Очир	-(Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн)

2.

Д.Баярчулуун -("Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн техник бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга бөгөөд дэд станц туршилт нормчлолын инженер)


Э.Түвшинбаяр -"Хөгжил Энержи" ХХК-ийн гүйцэтгэх захирал

Х.Нордог -"Хөгжил Энержи" ХХК-ийн ашиглалтын инженер

Нарийн бичгийн дарга:М.Мөнхцэцэг-(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын инженерийн барилга байгууламж хариуцсан мэргэжилтэн)

2.ЦДАШ, дэд станцын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг танилцуулахыг комисс (Г.Чинбат)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР